



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

2018 оны 5 дугаар сарын 10-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :

1. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын жагсаалтыг 1 дүгээр хавсралт, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх импортоор оруулж байгаа мод, модон материалын жагсаалтыг 2 дугаар хавсралт, гаалийн албан татвараас чөлөөлөх импортоор оруулж байгаа мод, модон материалын жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.
3. Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.ЦЭРЭНБАТ

**Засгийн газрын 2019 оны 101 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт
НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ
ОЙЖУУЛАЛТ,
ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ
АЖЛЫН
ЖАГСААЛТ**

№	Салбар	Дэд салбар	Бүлэг	Анги	Ажлын нэр	Тайлбар
1.	А	02	Ойн аж ахуй, мод бэлтгэл			

			021	0210	Мод тарих үйл ажиллагаа болон ойн аж ахуй	-Сор, шилмэл мод, үр бэлтгэх ой сонгох, плантаци байгуулах, мод, сөөгний үр боргоцой бэлтгэж боловсруулах, чанарын шинжилгээ хийх, тарьц, суулгац ургуулах, ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, байгалийн сэргэн ургалтанд туслах, ойн зурвас, модлог ургамлын цэцэрлэг байгуулах, голын эх, эрэг дагуу мод тарьж төгөл байгуулах, баянбүрд бий болгох зэрэг ажил, үйлчилгээ, тэдгээрийн зураг төсөл боловсруулах ажлыг ойлгоно.
			022	0220	Мод бэлтгэл	
			023	0230	Ойн дагалт нөөцийг түүх үйл ажиллагаа	-Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажил, ойн болон дагалт нөөцийн ашиглалт, хамгаалалт, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, мод бэлтгэлийн талбай тусгаарлах, ойн хөнөөлт шавж, өвчин, ойн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэж, хамгаалах зэрэг ажил, үйлчилгээг ойлгоно.
			024	0240	Ойн аж ахуйн туслах үйл ажиллагаа	-Дээрх ажил, үйлчилгээнүүдээс бусад төрлийн ойн аж ахуйн бүх төрлийн туслах үйл ажиллагааг ойлгоно.

						-Хот, суурин газарт мод, сөөг тарих, тэдгээрийг арчлах, таналт хийх, цэцгийн мандал байгуулах, талбайн, зүлэгжүүлэлт хийх, ургамал тарьж арчлах, хамгаалахтай холбоотой ажил, үйлчилгээ, тэдгээрийн зураг төсөл (7110 ангид хамаарах архитектор, инженерийн үйл ажиллагаа болон холбогдох техникийн зөвлөх үйлчилгээ хамаарахгүй) боловсруулах ажлыг ойлгоно.
2.	N	81	813	8130	Газар хамгаалах, арчлах үйлчилгээ	-Энэ ангид ургамал, модыг худалдах зорилгоор ургуулах үйлдвэрлэл явуулах (дэд салбар 01, 02-т), ойн мод арчилгаанаас бусад мод арчилгаа (0130-т), хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг ашиглалтад байлгах арчилгаа, үйлчилгээ (0161-т), газрын гадаргыг арчлах зорилгоор барилгын үйл ажиллагаа явуулах (салбар F-т), газар зохион байгуулалт, зураг төслийн үйл ажиллагаа (7110-т), ботаникийн цэцэрлэгийн үйл ажиллагаа (9103-т) хамаарахгүй.

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ
ИМПОРТООР ОРУУЛЖ БАЙГАА МОД, МОДОН МАТЕРИАЛЫН
ЖАГСААЛТ**

№	БТКУС-ийн код	Модон материалын нэр
1.	4401.11.00	Шилмүүст төрлийн, урт хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 6см<; урт 2.20м)

2.	4401.11.00	Шилмүүст төрлийн, хэрчим, цуулж хагалсан хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 15см-ээс дээш, урт 0.25м; 0.3м; 0.5м; 0.75м)
3.	4401.12.00	Навчит төрлийн, урт хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 6см<; урт 2.20м)
4.	4401.12.00	Навчит төрлийн, хэрчим, цуулж хагалсан хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 15см-ээс дээш, урт 0.25м; 0.3м; 0.5м; 0.75м)
5.	4410.12.00	Тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан; (OSB)
6.	9406.10.30	Стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц.

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ МОД,
МОДОН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

№	БТКУС-ийн код	Модон материалын нэр
1.	4401.11.00	Шилмүүст төрлийн, урт хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 6см<; урт 2.20м)
2.	4401.11.00	Шилмүүст төрлийн, хэрчим, цуулж хагалсан хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 15см-ээс дээш, урт 0.25м; 0.3м; 0.5м; 0.75м)
3.	4401.12.00	Навчит төрлийн, урт хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 6см<; урт 2.20м)
4.	4401.12.00	Навчит төрлийн, хэрчим, цуулж хагалсан хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 15см-ээс дээш, урт 0.25м; 0.3м; 0.5м; 0.75м)
5.	4410.12.00	Тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан; (OSB)
6.	9406.10.30	Стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц.